



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.07.31 № 01/6dd
танай _____ -ны № _____ -т

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
ТАНХИМЫН ДАРГА Д.БАТЧИМЭГ
ТАНАА**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох Хөвсгөл аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор Хөвсгөл аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Хөвсгөл аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын сонгуулийн мөрийн хөтөлбөр (2 хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Хөвсгөл аймгийн Иргэдийн оролцооны нэгдэл намын танхимд

Хувийг: Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Сонгуулийн хороонд.

Хавсралт *2* хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР

**ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМЫН
АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

Хүний эрх, хувийн хэвшил, тогтвортой хөгжил, иргэний оролцоог эрхэм болгодог баруун төвийн намын хувьд Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам (ИОНН) “боловсрол, бизнесийн орчин, тогтвортой хөгжил” гэсэн гурван голлох чиглэлээр улс орныхоо хөгжилд дэвшилтэт өөрчлөлтийг авчрах зорилт тавин мөрийн хөтөлбөрөө дэвшүүлж байна. Үүнд:

Нэг: Боловсролын чиглэлээр

Боловсрол бол Монгол улсын өнөөдөр болон ирээдүйн гол хөрөнгө оруулалт юм хэмээн ИОНН үзэж буй тул “Тэгш хүртээмжтэй сургууль” хөтөлбөрийг онцгой анхаарч ажиллана. Энэхүү хөтөлбөр нь бага дунд болон насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, эцэг, эх, асран хамгаалагч нарын хөдөлмөр, бизнес эрхлэх боломжийг хангах, хүн амын суурь эрүүл мэндийн асуудлыг багасгах, хот байгуулалт, нийтийн тээврийн тулгамдсан асуудлыг эергээр шийдвэрлэх, хүүхдийг эрүүл аюулгүй орчинд өсгөж боловсролтой иргэн болгоход гүн гүнзгий нөлөө үзүүлэх болно. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд:

- 1.1. Сургуулийн орчин анги танхимын эрүүл аюулгүй байдал Монгол Улсын стандартад нийцэж буй эсэхэд олон нийтийн анхаарлыг хандуулна.
- 1.2. Аюулгүй байдал эрүүл ахуйн мэдлэгийг хүүхэд бүрд хүргэх ажлыг зохион байгуулна.
- 1.3. Хүүхдийн сурах орчинд сургууль, анги танхим, багш, гэр бүл, сургуулийн эргэн тойрны зай талбай, орчны хөршүүд, нутаг орны байршил, уур амьсгал, цаг уурын нөлөө зэрэг багтах тул сургуулийн үйл ажиллагааны дүрэм, сургалтын хөтөлбөр зэргийг дээрээс батлахад нь тусгуулах зорилгоор тухайн орон нутгийн иргэд, сургууль дундын сургалтын мэргэжилтэн, тухайн сургуулийн багш, эцэг эх, асран хамгаалагч нарын санал хүсэлтийг хэлэлцүүлэх, хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлж зохион байгуулна.

Хоёр. Бизнесийн орчны чиглэлээр: Шударга татвар- Тэгш орчин

Хувийн хэвшил бол улс орны эдийн засгийн гол хөдөлгөгч хүч гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг учраас хувийн хэвшилд бизнесийн тэгш боломж, эрүүл өрсөлдөөний орчныг хангах нь бидний гол зорилтын нэг юм. Өнөөгийн бизнесийн орчин нь улс төр маш их холилдсон, цөөн хэдэн компани шударга бус давуу байдлаа ашиглан бусдынхаа бизнесийн орон зайг хумьсан, бизнес эрүүлээр өсөж өндийх, тэлэх нөхцөл алдагдсанаас үүдэн залуучууд эх орондоо бизнес хийхээс шантарч олноороо гадаад улс руу гарах болсон нь манай орны хөгжлийг хойш татах хэмжээнд хүрлээ гэж ИОНН үзэж байна. Иймээс татвар, төсөв, өрсөлдөөний бодлогыг доорх байдлаар өөрчилж бизнесийн орчныг сайжруулна. Үүнд:

- 2.1. Орон нутгаас өгдөг аливаа тусгай зөвшөөрөл, хяналт шалгалтыг цөөлөх болон шаардлагатай гэж үзвэл зайлшгүй олгох ажлыг хөнгөвчлөх ажлыг зохион байгуулна.

- 2.2. Тухайн аймаг сумын иргэн төрийн худалдан авалтад оролцох мэдээллийн ил тод байдлыг бий болгож, хэрэв хуулиар заасан шаардлагыг хангасан бол тухайн сум, аймгийн бизнес эрхлэгч давуу эрхтэй оролцох ажлын талаар хууль тогтоомжид оруулах өөрчлөлтийг санал болгож, журам боловсруулна.

Гурав. Тогтвортой хөгжлийн чиглэлээр

Байгаль орчин, иргэний боловсрол нь тогтвортой хөгжлийн бат суурь гэж Иргэдийн Оролцооны Нэгдэл Нам үздэг ба дараах бодлогыг иргэдийн идэвхтэй оролцооны тусламжтайгаар хэрэгжүүлнэ. Үүнд:

- 3.1. Хур тунадас багатай, гандуу хуурайгаас үүдэн гамшиг тохиолдох магадлалтай сум орон нутагт иргэд ганцаараа буюу хамтран өөрийн болон дундын эдэлбэр газарт ногоон байгууламж барих ажлыг зохион байгуулна.
- 3.2. Монгол орны байгаль цаг уур, газар зүйн нөхцөл байдлын онцлогт нийцсэн, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох аливаа үйл ажиллагааг иргэд хувийн хэвшилтэй хамтран шийдэж үр дүн гарч байгаа бол тэдгээр үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохион байгуулалтын ухаалаг дэмжлэг үзүүлнэ.
- 3.3. Орчны бохирдлыг багасгах, иргэдийн эрүүл аюулгүй байдлыг сайжруулах тал дээр иргэдийн оролцоотой, тогтвортой шийдлийг боловсруулж зохион байгуулна.
- 3.4. Аливаа бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын ажлыг иргэдийн оролцоогүйгээр шийддэг байдлыг халахын тулд орон нутгийн удирдлагад тавих иргэний хяналтыг идэвхжүүлнэ.
- 3.5. Аливаа бүтээн байгуулалт болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг эхлэхээс хамгийн багадаа нэг жилийн өмнө үйл ажиллагаанд шууд өртөх иргэдтэй уулзалт, танилцуулга эхлүүлсэн байх, бүтээн байгуулалтын явцад болон хүлээлгэн өгөхөөс өмнө иргэдэд мэдээлэл өгөх ажлыг шаардаж, зохион байгуулна.
- 3.6. Иргэдээс ирсэн саналыг үндэслэн иргэдэд ээлгүй, сөрөг нөлөөтэй, үр ашиг муутай төсөл хөтөлбөрт нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэх ажлыг зохион байгуулна.
- 3.7. Хэрэв Төрийн болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар аливаа бүтээн байгуулалт хийж буй бол тухайн бүтээн байгуулалтын байршил сонгох асуудлаар заавал нийтийн сонголт хийдэг болгоно. Төрийн байгууллагын санаачилгаар уг бүтээн байгуулалтыг хийх бол нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулдаг болгоно.
- 3.8. Хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл нь иргэдэд учрах гамшгийн аюулыг нэмэгдүүлж байгаа эсэхийг тогтоодог болгоно.
- 3.9. Иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагууд, тухайлбал холбоод, үйлдвэрчний эвлэлүүд, бусад олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих, идэвхжүүлэх ажлыг зохион байгуулна.